



**ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ХЭРЛЭНБАЯН-УЛААН ТОСГОНЫ ЗАХИРАГЧИЙН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/04

Хэрлэнбаян-Улаан тосгон

**Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн
баталгааг хангах хөтөлбөр батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3, 61 дүгээр зүйл, 62 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Захирагчийн ажлын албаны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг жил бүр боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Б.Энхсаруул)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (А.Нарантуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОТГОНБАЯР



ХЭРЛЭНБАЯН УЛААН ТОСГОНЫ ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ АЛБАН ХААГЧИЙН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийн зорилго

Төрийн албан хаагчдын ажиллах орчин нөхцлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах, тэдгээрийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, эрүүл мэндийг хамгаалахтай холбогдсон асуудлыг шийдвэрлэж, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлоход оршино.

Хоёр. Хөтөлбөрийн зорилт

2.1. Төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөн төлбөр, тусламж, шагнал урамшууллыг хууль журамд нийцүүлэн олгох;

2.2. Ажиллах орчин нөхцөлийг сайжруулах

2.3. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах

2.4. Албан хаагчдын мэдлэг, мэргэжил, ур чадварыг байнга дээшлүүлэх

Гурав. Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийг дор дурьдсан эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

- Байгууллагын жил бүрийн төсөвт батлагдсан хөрөнгө
- Төсвийн хэмнэлт
- Бусад эх үүсвэр

Дөрөв. Хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1. Төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөн төлбөр, тусламж, шагнал урамшууллыг хууль журамд нийцүүлэн олгох зорилтын хүрээнд:

1. Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан цалингийн сүлжээг баримтлан албан хаагчдын цалинг тухай бүр шинэчлэн тогтоож мөрдөх

2. Төрийн албан хаагчдад олгох нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг Засгийн газрын тогтоол, шийдвэрийг баримтлан тогтоож олгох

3. Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүнг харгалзан зэрэг дэв нэмэгдүүлэх асуудлыг Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлөөр шийдвэрлүүлэх

4. Албан хаагчдын ажилласан жилийг харгалзан төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг журмын дагуу тухай бүр олгож байх

5. Албан хаагчдын ажилласан хугацаа, ажлын үр бүтээл, идэвх санаачлагыг харгалзан мөнгөн урамшууллыг олгож байх

6. Албан хаагчид түлээ, нүүрс худалдан авахад нь төсвийн байдлаас хамаарч дэмжлэг үзүүлэх

7. Ганц бие, өрх толгойлсон болон шинээр гэр бүл болсон, шинэ хүүхэдтэй залуу гэр бүлд эд хөрөнгийн болон санхүүгийн тусламж, дэмжлэг үзүүлэх

8. Албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гутгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас албан хаагч, түүний гэр бүлийн гишүүнийг хамгаалах арга хэмжээ авах

9. Салбарын шагнал, төрийн одон медальд болзол журмыг нь хангасан тухай бүрд нь албан хаагчдыг тодорхойлж байх

4.2. Ажиллах орчин нөхцөлийг сайжруулах зорилтын хүрээнд:

1. Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай бичгийн хэрэгсэл, ширээ, сандал, компьютер, принтер, скайнер, хувилагч болон бусад техник хэрэгслээр хангах;
2. Албан үүргээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай үед унаагаар хангах;
3. Ажлын байрны орчин нөхцлийг сайжруулах; /халаалт, гэрэлтүүлэг, өрөөний тохижилт, цахилгаан хангамжийн үйлчилгээ, гэх мэт /
4. Үйлчилгээний ажиллагсдыг ажлын хувцас, хамгаалах болон үйлчилгээнд шаардагдах хэрэгсэл, материалаар тасралтгүй хангах;

4.3. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах зорилтын хүрээнд:

1. Төрийн албан хаагчдыг жилд нэг удаа нарийн мэргэжлийн эмч нарын шинжилгээ, үзлэгт хамруулж шаардлагатай хүмүүст эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, амралт сувилалд явахад нь дэмжлэг үзүүлэх;
2. ЗААлбаны албан хаагчид хүнд өвчний улмаас 3 дахь шатлалын эмнэлэгт эмчлүүлэх шаардлагатай тохиолдолд эмнэлгийн бичгийг үндэслэн дотоод журамд заасны дагуу тусламж, дэмжлэгийг үзүүлэх;
3. Байгууллагын ажиллагсдыг 7 хоногт 1 удаа спорт зааланд чөлөөт цагаа өнгөрөөх нөхцлийг бүрдүүлэх
4. Амралт чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэсэн арга хэмжээ, уралдаан тэмцээн, үзвэр үйлчилгээ, аялал зугаалга зэрэг нийтийг хамарсан арга хэмжээг жил бүр зохион байгуулах

4.4 Албан хаагчдын мэдлэг, мэргэжил, ур чадварыг байнга дээшлүүлэх зорилтын хүрээнд:

1. Төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх мэргэжлийн сургалтанд хамруулах
2. Ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг ур чадварыг олгох сургалтыг зохион байгуулах

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах үр дүн

- Төрийн албан хаагчид ажиллах нөхцөл, бололцоогоор бүрэн хангагдаж, ажлаа тав тухтай хийх орчин бүрдэнэ.
- Төрийн албан хаагчид шаардагдах техник хэрэгслэлээр бүрэн хангагдаж, тухайн үеийн тавигдаж байгаа шаардлагад нийцүүлэн ажлаа явуулах бололцоотой болно.
- Төрийн албан хаагчдын цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, нөхөх төлбөр тухайн үед мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу бүрэн тогтоогдож олгогддог асуудал хэвшил болно.
- Төрийн албан хаагчийн амьдрах орчин нөхцөл зохих хэмжээгээр дээшилнэ.
- Төрийн албан хаагчийн эрүүл мэндийг хамгаалах асуудал сайжирч, тэдний өвчлөл буурч, төрийн үйлчилгээний үр дүн сайжирна.

ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА